

Эдийн засгийн огцом өсөлт бий боллоо


2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ оны үнээр 10,830 тэрбум төгрөг болж, эдийн засгийн өсөлт 17.3%-д хүрэв.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын өсөлт буурч байхад энэ нь олон улсын хэмжээнд хамгийн өндөр өсөлт байлаа. Уул уурхайн тэсрэлт, дэлхийн зах зээл дэх зэсийн өндөр үнэ, нүүрс болон төмрийн хүдрийн экспорт эрс нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дагуулж байна.



Улсын төсөвт төвлөрүүлсэн НӨАТ-ын орлогын хэмжээ 41% нэмэгдэв

Энэ оны эхний улирлын байдлаар улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.9%, зарлага 34.5% тус тус өсч, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 56 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд НӨАТ, НДШ, ААНОАТ-ын орлогын өсөлт хамгийн их нөлөөлсөн бол зарлага нэмэгдэхэд чалин хөлсний зардал 15%, татаас ба шилжүүлэг 13% өссөн нь нөлөөлжээ.




Импортын өсөлтийн хурд бага зэрэг саарлаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28% нэмэгдэж, 2.3 тэрбум ам.долларт хүрлээ.

Экспорт 19%, импорт 34% өссөн нь өнгөрсөн сартай харьцуулахад буурсан үзүүлэлт байв.

Экспортын өсөлтөд нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй газрын тосны экспорт нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин зэсийн баяжмалын экспорт 18% буурсан байна. Импортын өсөлтөд шатахуун, автомашины импортын өсөлт голлон нөлөөллөө.



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байна

Энэ сарын дунджаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх сараас 0.6%, оны эхнээс 3.0% чангарлаа.

Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.5% суларчээ. Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 18% нэмэгдэв.

МБ арилжааны банкуудын саналын дагуу гадаад валютын нийт 9 дуудлага худалдаанд оролцож, 2 удаагийн саналыг биелүүлэн 97.3 сая ам.доллар худалджээ.



Инфляц дээд амжилт тогтоолоо

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад инфляцын сарын, жилийн болон оны эхнээс тооцсон түвшин бүгд өссөн байна.

Улсын хэмжээнд инфляцын жилийн түвшин 15.3%-д хүрсэн нь сүүлийн 2 жил байгаагүй өндөр түвшин байв.


Энэ өсөлтөд хүнсний барааны үнийн дундаж түвшин 24.5%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 18.6%, тээврийн үйлчилгээний үнэ 16.6% өссөн нь голлон нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сартай харьцуулахад буурав

M2 мөнгө буюу мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23% нэмэгдсэн ч өнгөрсөн сартай харьцуулахад 2% буурлаа. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний эзлэх хувь мөн буурч байна. Мөнгөний нийлүүлэлт буурахад хадгаламж, тэр тусмаа гадаад валютын хадгаламж буурсан нь нөлөөлжээ.



Валютын хадгаламжийн хэмжээ буурч эхэллээ

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.5% нэмэгдсэн бол өнгөрсөн сартай харьцуулахад 0.5% буурсан байна. Төгрөгийн хадгаламжийн өсөлт удааширсан хэвээр байгаа бол гадаад валютын хадгаламжийн хэмжээ өмнөх сараас 23.4%, өмнөх оны мөн үеэс 3.5%-иар эрс буурсан үзүүлэлттэй байлаа. Төгрөгийн ханш өнгөрсөн сард өмнөх сартай харьцуулахад тогтвортой байсан нь гадаад валютын хадгаламж ханшийн өөрчлөлтөөс хамааралгүй өссөн болохыг харуулж байна.



Зээл тогтвортой байна

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сартай харьцуулахад төдийлөн өөрчлөлтгүй тогтвортой, харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээл өссөн, чанаргүй зээлийн хэмжээ буурсан дүр зураг хэвээр байна.



Эх сурвалж: УЦХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монгол банкны бодлогын хүү III сард 12.75% болж, IV сард 13.25% болж нэмэгдлээ.
- > Монголын Эдийн Засгийн Чуулган болов.
- > Чуулганы үеэр Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадварын Судалгааны Төв "Монгол улсын өрсөлдөх чадварын тайлан 2011" тайлангийн англи хэл дээрх хувилбарыг танилцууллаа.
- > Монгол Улс Дэлхийн банкны Олон Улсын Сэргээн босголт, Хөгжлийн Банкнаас зээлжих эрхтэй боллоо.
- > Монголын Хөгжлийн банк олон улсын зах зээл дээр 580 сая ам.долларын бондыг, 5.75 хувийн хүүтэйгээр, 5 жилийн хугацаатай гаргав.
- > Төрийн албан хаагчдын цалинг II сараас тооцон эхний ээлжинд 80 мянган төгрөгөөр, V сараас 23% нэмэхээр Засгийн Газар шийдвэрлэлээ. Ийнхүү төрийн албан хаагчдын дундаж цалин 630 мянган төгрөгт хүрч байна.

Хураангуй

Улсын төсвийн алдагдал нэмэгдэж байгаа ч НӨАТ, НДШ, ААНОАТ зэрэг татварын орлого өсч буй нь бизнесийн салбар тэлж буйг илтгэж байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт өссөн ч импортын хэмжээ экспортын хэмжээнээс 1.6 дахин их байгаа нь гадаад худалдааны алдагдлыг бий болгож байна. Төсөв, гадаад худалдааны алдагдал ийнхүү нэмэгдэж буй нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах нөхцөлийг бүрдүүлж буй. Гэвч сүүлийн 2 сарын хугацаанд ханш чангарсан нь МУ-ын Хөгжлийн банк бонд гаргасан, ноос ноолуурын улирал эхэлсэн зэрэг нь хүлээлтэд нөлөөлсөнөөс үүдсэн түр зуурын үзэгдэл болов уу хэмээн таамаглаж байна. Гадаад худалдааны алдагдал өссөөр байгаа ийм үед ханш буцаад сулрах төлөвтэй. Нийлүүлэлтийн хомсдол, төсвийн тэлэлтээс үүдсэн инфляц улсын хэмжээгээр 15.3%-д хүрсэн нь Монгол Банк яаралтай мөнгөний бодлогоо чангаруулахад хүргэлээ. Энэ нь зээлийн хүүг өсгөх сөрөг талтай ч иргэдийн нуруун дээрх инфляцийн дарамтыг бууруулахын тулд үүнээс өөр арга байхгүй хэмээн тайлбарлаж байна. Банкны систем дэх зээлийн үлдэгдэл харьцангуй тогтвортой байгаа бол мөнгөний нийлүүлэлт буурлаа. Энэ нь иргэдийн хадгаламжийн хэмжээ ерөнхийдөө буурч байгаа, түүн дотор төгрөгийн ханш сүүлийн 2 сар чангарсан, ханш чангарна гэсэн хүлээлт бий болсонтой холбоотой валютын хадгаламж илүүтэй буурсанаас үүдэлтэй.